

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 50 ДУГААР
ЗҮЙЛИЙН А) ХЭСЭГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД
НЭГДЭН ОРОХ ТУХАЙ САНАЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлсэн Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ хэлэлцэж буй асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, сүүлийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан иргэний нисэхийн навигацийн орлого буурч байгаатай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай, Өмнөговь аймагт олон улсын нисэх буудал байгуулах асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс дэмжиж байгаа эсэхийг асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БАТТӨМӨР